159

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

20 16 .оны 03 дугаар сарын 21-ны өдөр | Дугаар .38. | Багануур

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дэх заалт, “Багануурын дулааны станц”ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг.“Багануурын дулааны станц”ТӨХК-ийн хэмжээнд мөрдөх “Аюулыг мэдээлэх хуудсыг ашиглах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Аюулыг мэдээлэх хуудас”-ын загварыг хоёрдугаар хавсралтаар, “Аюулыг шалгах жагсаалт”-ын загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалыг 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн удирдах ажилтнууд, ИТА, ажиллагсад дагаж мөрдсүгэй.

Гурав. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн хэлтэс Д.Дандар, ХХ-ын инженер Ц.Оюунбүрэн, Дотоод хяналтын ажилтан З.Оюун-Эрдэнэ нарт тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЖАРГАЛСАЙХАН

Tushaal-2016

"БНДС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
20.16 оны .03 дугаар сарын 31-ны өдрийн
58 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Аюулыг мэдээлэх хуудсыг ашиглах журам

1. Холбогдох бичиг баримтууд

- *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /2008/*
- "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн систем" стандарт /МАОЭНХ, 2010 он/
- "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2013 оны 20-р тогтоол.
- "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний дэрэв дэх хөтөлбөр /НХХС-ын 2012 оны 122-р тогтоол/

2. Зорилго

2.1 Компанийн хэмжээнд болзошгүй осол аваари гарахаас урьдчилан сэргийлэх ажилд ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

3. Журмыг дагаж мөрдөх ажилтнууд

3.1 Энэхүү журмыг ""БНДС" ТӨХК-ийн харьяа бүх нэгжүүд /алба, хэлтэс, хэсгүүд/-д бүх удирдах ажилтан, инженер техникийн ажилтан, мэргэжлийн ажиллагсад дагаж мөрдөнө.

4. Журмын дэлгэрэнгүй тодорхойлолт

Ерөнхий зүйл

4.1 Компанийн үйл ажиллагааны хүрээнд Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангаагүй осол гарах нөхцөл бүрдсэн, бусдын алдаа болон зөрчлүүдийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд болон эд хөрөнгийн ноцтой хохирол учруулж болзошгүй аюулыг илрүүлж, ажлын байрны аюулгүй байдлыг бүрэн хангахаар урьдчилан мэдээлж, холбогдох арга хэмжээ

авахуулснаар болзошгүй осол аваари гарахаас урьдчилан сэргийлэх ажилд ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Энэхүү журмыг хэрэгжүүлэхийн тулд "АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС"-ыг ашиглана.

5. Журмыг мөрдөгч талуудын үүрэг, аюулыг мэдээлэх хуудсыг хэрэглэх орчин

5.1. "Аюулыг мэдээлэх хуудас", ."Аюулыг мэдээлэх хуудсыг бүртгэх дэвтэр", *"Аюулыг мэдээлэх хуудас хүлээн авах хайрцаг" нь компанийн хэмжээнд нэг эх* загвартай байх ба тэдгээрийг компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженерийн нэгтгэсэн захиалгын тоогоор хэвлүүлэх, бэлтгэх үүргийг Хангамжийн менежер хариуцан гүйцэтгэж, компанийн бүх нэгжийн ИТА ажилтнаар дамжуулан тараана. Мэдээлэгч нарт "Аюулыг мэдээлэх хуудас"-ыг тараахдаа серийн дугаарын дагуу бүртгэлээр хүлээлгэн өгнө.

5.2. "Аюулыг мэдээлэх хуудас"-ыг "БНДС" ТӨХК-ийн Захирлын тушаалаар томилогдон ажиллаж байгаа бүх удирдах ажилтан, инженер техникийн ажилтан, мэргэжлийн ажиллагсад биедээ байнга авч явах ба илэрсэн аюулыг бичиж мэдээлнэ.

5.3. "Аюулыг мэдээлэх хуудас" хүлээн авах цоож түлхүүртэй хайрцагийг компанийн [illegible] оффис, хэсгийн ажлын байруудад байршуулах ба хайрцагны бүрэн бүтэн [illegible]йдалд хяналт тавих, хайрцагийг нээж хуудас авах үүргийг Дотоод хяналтын [illegible]лтан хариуцна. Дотоод хяналтын ажилтан байхгүй үед ХАБЭА-н инженер [illegible]ариуцна.

5.4. Мэдээлэгч нь аюул, осолд дөхсөн тохиолдол, түүнийг арилгах, устгах арга хэмжээний тухай мэдээлэлээ "Аюулыг мэдээлэх хуудас"-нд асуултын дагуу бүрэн тодорхой бичээд, 1 хувийг өөртөө хадгалж, 1 хувийг хэсгийн ИТА, 1 хувийг Ээлжийн инженерт өгөөд, 1 хувийг "Аюулыг мэдээлэх хуудас" хүлээн авах хайрцагт хийнэ.

5.5. Компанийн төв оффис, ажлын байр болон хэсгүүдэд байрлуулсан хайрцгийг өдөр бүр тогтсон цагт нээнэ.

5.6. Хэсэг хариуцсан ИТА нь аюулын тухай мэдээллийн бодит байдалтай биечлэн танилцах, тухайн асуудлаар харьяа алба, хэлтэс, удирдлагуудтай ярилцан мэдээллийн дагуу хурдан арга хэмжээ авах, ХАБЭА-н инженер, Дотоод хяналтын ажилтан болон мэдээлэгчид хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

5.7. Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал болон алба хэлтэсийн дарга нар нь "Аюулыг мэдээлэх хуудас"-ны мөрөөр гүйцэтгэх ажлын талаар шийдвэр гаргах, арга хэмжээний биелэлтэнд хяналт тавих үүрэг хүлээнэ.

5.8. Компанийн ХАБЭА хариуцсан инженер болон Дотоод хяналтын ажилтан нь

компанийн хэмжээнд бүртгэгдсэн "Аюулыг мэдээлэх хуудас", түүний мөрөөр гүйцэтгэсэн ажлын нэгдсэн мэдээ гарган компанийн удирдлага, ХАБЭА-н орон тооны бус зөвлөлд тайлагнах, шагнал урамшуулал, арга хэмжээний асуудлаар санал оруулах үүрэг хүлээнэ.

6. Урамшуулал, хариуцлага, хяналт

6.1. Ноцтой, аюултай үр дүнд хүргэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, зөв мэдээлэл өгсөн мэдээлэгч нар болон өгсөн мэдээллийн дагуу аюул ослоос урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой шийдвэрлэж зохион байгуулж чадсан 5 хүртэл тооны мэдээлэгчийг жилийн эцэст Захирлын зөвлөлийн хурлаар сонгон шалгаруулж, компанийн зүгээс урамшуулал олгоно.

6.2. Урамшууллын хэмжээ нь: Мэдээлэгчид 10 000-100 000₮

6.3. Компанийн бүх нэгжүүдэд удирдах ажилтан, ИТА болон мэргэжилтэй ажиллагсдын сар, улирал, жилийн ажлыг дүгнэхдээ "Аюулыг мэдээлэх хуудас"-ыг ашигласан байдал, түүний мөрөөр хийгдсэн ажлын үр дүнг заавал тооцож ажиллана.

6.4. Мэдээлэгч нь "Аюулыг мэдээлэх хуудас"-ыг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд ХАБЭА хариуцсан инженер болон Дотоод хяналтын ажилтнаас нэн даруй мэдэгдэж нөхөн авах ба үрэгдүүлсэн хуудсыг хэвлүүлэхэд зарцуулсан зардлын үнийг төлж, компанийг хохиролгүй болгоно.

6.5. "Аюулыг мэдээлэх хуудас"-ны дагуу тодорхой ажил зохион байгуулаагүйн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд болоод компанид эд хөрөнгийн хохирол учирсан бол буруутай нэгжийн удирдлага, хувь хүмүүст Монгол улсын хууль, компанийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.6. Журмын хэрэгжилтэнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженер, ХАБЭА-н зөвлөл, Дотоод хяналтын ажилтан болон ЗХНХэлтэс хяналт тавьж ажиллана.

Журам боловсруулсан:ХХ-ын инженер Ц.Оюунбүрэн

"БНДС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2014 оны 05 дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Аюулыг мэдээлэх хуудасны хавтасны "А" /нүүрэн тал/

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК

АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

АЮУЛГҮЙ АЖИЛЛАЦГААЯ.

Аюулыг мэдээлэх хуудасны хавтасны "Б" /ар тал/

АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ СИСТЕМ НЬ ДАРААХ БАЙДЛААР ЯВАГДАНА:

МЭДЭЭЛЭГЧ

ХАБЭА-н ИНЖЕНЕР, ДХА

ХЭСГИЙН ИТА , ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР

АЛБА / ХЭЛТЭСИЙН ДАРГА

Мэдээлэх хуудас нь 4 хувь байна.

1.Мэдээлэгч
-АА-ны хэсгийн хурал дээр хэлэлцэхээр нэг хувийг өөртөө авна.

2.Хэсгийн ИТА
- бүртгэж, хариу арга хэмжээ авахаар нэг хувийг авна.

3.ХАБЭА-н инженер, Дотоод хяналтын ажилтан
- Мэдээллийг хянаж үзээд, бүртгэх
- Бусад хэсгүүдэд нөлөөлөх эсэхийг шалгах
- Шаардлагатай бол ХАА-ны мэдээ гаргах
- Мэдээлэгчид авсан арга хэмжээний талаар мэдэгдэх

4. Ээлжийн инженер
- Мэдээллийг хүлээн аваад, шуурхай арга хэмжээ авах

Аюулыг мэдээлэх хуудас:

АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС №

ОГНОО: ..... / ..... / ..... ЦАГ: .....
БАЙРЛАЛ: .....
АЮУЛ: .....
.....
.....
.....
ХОХИРЛЫН ТӨРӨЛ: Амь нас эрсдэх, бэртэх, гал түймэр, хамгаалалтгүй болох, бохирдол, тааламжгүй байдал, осолд дөхсөн тохиолдол, байгаль орчинд хохирол учрах, үйлдвэрлэлийн алдагдал, бусад
ХОХИРЛЫН ХЭМЖЭЭ: Их, ноцтой, бага
АВАХ АРГА ХЭМЖЭЭ:
.....
.....
.....
.....
.....
МЭДЭЭЛСЭН: ..... ХД.....
ТЕЛ: .....
АЛБА/ХЭЛТЭС:..... ХЭСЭГ .....
ХЭНД МЭДЭЭЛСЭН: .....
АВАГДСАН АРГА ХЭМЖЭЭ:
.....
.....
.....
.....
АРГА ХЭМЖЭЭ АВСАН ОГНОО: .....
АРГА ХЭМЖЭЭ АВСАН .....
/ Хэсгийн ИТА, ДХА/

"БНДС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
20..... оны ..... дугаар сарын ...-ны өдрийн
.... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ " ТӨХК-Д АЮУЛЫГ ШАЛГАХ ЖАГСААЛТ

- Таны болон танай хэсгийн ажилчдын биеийн эрүүл мэнд ажилд ороход бэлэн үү?
- Таны болон танай хэсгийн ажилчдын аюулгүй ажиллагааны бүрэлдэхүүн, групп, мэргэжлийн зэрэг хүрэлцээтэй байна уу?
- Хүчтэй салхи, шуургатай байна уу?
- Хэт халуун, хэт хүйтний аюул байна уу?
- Ажлын байрны бэлтгэлд эргэлзээ байна уу?
- Унах, хальтрах, тээглэх аюул байна уу?
- Шат, тавцан, өндрөөс унах аюул байна уу?
- Ялзарч муудсан тулгуур, модон эдлэл байна уу?
- Цохих, мөргөх, цохигдох аюул байна уу?
- Тэсэрч, дэлбэрэх, шатах, хорт хий, тэсрэмтгий шингэний ууршилт, химийн бодис, амьсгалах эрхтэн гэмтээх тоосонцор зэрэгт өртөх аюул байна уу?
- Шошго, хаяггүй бодисууд ажлын байранд байна уу?
- Гүйдэл, хүчдэлд нэрвэгдэх аюул байна уу?
- Цахилгааны хэт ачааллын аюул байна уу?
- Үзэгдэх орчин хязгаарлагдмал байна уу?
- Бусдыг гэмтээх аюул байна уу?
- Багаж, хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжинд гэмтэл байна уу?
- Эрүүл мэндэд хортой ямар нэгэн материал, эд зүйлс, бүтээгдхүүн байна уу?
- Эргэх механизмд орооцолдох аюул байна уу?
- Ажлын байрны аюулын гарц чөлөөтэй байж чадаж байна уу?

ЭДГЭЭР ЖАГСААЛТААС АЛЬ НЭГ АЮУЛ БАЙГАА БОЛ АЖИЛД ОРОХЫН ӨМНӨ ЗААВАЛ МЭДЭЭЛЖ НЭМЭЛТ ХЯНАЛТ ТОГТООЛГОЖ БАЙ!